



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/84

Алтай хот

Гамшгийн сангаас хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2022 оны 3 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед улаан бүсэд ажилласан эмч, эмнэлгийн ажилтнуудад нэг удаагийн мөнгөн урамшуулал, мал амьтны гоц халдварт шүлхий өвчний голомтод ажилласан зардал, аймгийн "Нэгдсэн шуурхай штаб"-ын үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан хөрөнгийг Гамшгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.


2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 18 ны өдрийн 1/24 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Зардлын хэмжээ /төгрөг/
1	Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед улаан бүсэд ажилласан эмч, эмнэлгийн ажилтнуудад нэг удаагийн мөнгөн урамшуулал	84,000,000
2	Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний голомтод ажилласан алба хаагчдын томилолт	5,880,000
3	Аймгийн нэгдсэн шуурхай штабт шаардлагатай зардал	372,000
	Нийт дүн	90,252,000

__оОо__